

ИРАН:

ЯСАМАН АРИЯНИ

ЭРХИЙНХЭЭ
ТӨЛӨӨ
БИЧИЦГЭЭЭ

ЭМНЕСТИ
ИНТЕРНЭШНИ 

ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭРХИЙН ТӨЛӨӨ **ТЭМЦЭЖ** 16 ЖИЛИЙН ХОРИХ ЯЛААР ШИЙТГҮҮЛЭВ



ЯСАМАН АРИЯНИ

ИРАН

2019 оны Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрөөр Ираны жүжигчин эмэгтэй Ясаман Ариянийн хүчээр гивлүүр зүүлгэх тухай хуулийг эсэргүүцэж байгаагаа илэрхийлсэн юм. Ээжийнхээ хамтаар зөвхөн эмэгтэйчүүд суудаг галт тэргэнд орж, үсээ зоригтойгоор ил гарган, хүмүүст цагаан цэцэгс тараажээ. Тэрээр бүх эмэгтэйчүүд юу өмсөхөө өөрөө сонгодог эрх чөлөөтэй болох юм бол "хижабтай, хижабгүй" зэрэгцэн алхдаг болно хэмээн өөрийн итгэл найдварын тухай өгүүлсэн юм. Энэ мөч дүрс бичлэгт бууж, 2019 оны 3 дугаар сард олон нийтэд түгэж, шуугиан тарив.

4-р сарын 10-нд Ираны эрх баригчид Ясаманыг баривчилж, хэдэн өдрийн турш ганцаарчлан хорьж, байцаан, гадны нөлөөнд автаж ийм үйлдэл хийсэн, "үүндээ гэмшиж байгаа"-аа илэрхийлэн "хэргээ хүлээх"-ийг тулгасан байна. Хэлснээр нь хийхгүй бол гэр бүл, найз нөхдийг нь баривчилна хэмээн сүрдүүлжээ. 7-р сарын 31-нд Ясаманд 16 жилийн хорих ял оногдуулсан ба хамгийн багадаа 10 жил хоригдох нь зайлшгүй болоод байна.

Ясаманд оногдуулсан энэхүү харгис шийтгэл нь Иран улсын эмэгтэйчүүдэд гивлүүр зүүхийг албаддаг хуулийг эсэргүүцсэн эмэгтэйчүүдийн кампанит ажлын эсрэг авч буй эрс арга хэмжээний нэг хэсэг юм. 2018 оноос хойш олон эмэгтэйчүүд, Ясаманы ээж Монирех Арабшах ч мөн баривчлагдаад байна. Ираны эрх баригчид эмэгтэйчүүд юу өмсөхөө өөрсдөө сонгох эрхтэй байх ёстой гэх итгэл үнэмшлийнх нь төлөө Ясаманыг аз жаргалтай амьдралаас нь салгах ёсгүй юм.

ИРАНЫ ЭРХ БАРИГЧ НАРТ ХАНДАН ЗАХИДАЛ БИЧИЦГЭЭ

Ясаманыг нэн даруй, ямар нэг нөхцөлгүйгээр суллахыг шаардацгаая.

Head of the Judiciary Ebrahim Raisi

C/o Permanent Mission of Iran to the UN

*Chemin du Petit-Saconnex 28
1209 Geneva, Switzerland*

Twitter: @khamenei_ir

Instagram:
https://www.instagram.com/khamenei_ir/

ЯСАМАНД ЭВ САНААНЫ НЭГДЛЭЭ ИЛЭРХИЙЛЭЭРЭЙ

Ясаманы адил цэцэг тарааж, алчуураа авч үсээ ил гаргаж буй дүрс бичлэг хийж, эсвэл фото зураг авч түүнийгээ цахим хаягтаа оруулж, #FreeYasaman @yasamanaryani95, @khamenei_ir хаягаар таглаарай. Мөн та бичлэг, зургаа Iran_team@amnesty.org хаягаар илгээгээрэй.

**ЗАХИДАЛ БИЧИЖ
ӨӨРЧЛӨЛТ ХИЙЦГЭЭ**

December 2019
Index: MDE 13/0755/2019 English
Images: cover: © Private (Main image),
© Getty/Smartshots International
Back page: © Private